



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/126,

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 132 дугаар сургуулийн данс бүртгэлд хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 4 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалт, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хандивласан 6,250,680.0 (зургаан сая хоёр зуун тавин мянга зургаан зуун наяд) төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлд бүртгэн авахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 132 дугаар сургууль (Л.Батсайхан)-д зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 132 дугаар сургууль (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА  В.ОЮУМАА



Нийслэлийн өмчийн харилцааны газрын
даргын 2025 оны 11 дүгээр сарын 11-ны
өдрийн АБД дугаар тушаалын хавсралт

Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 132 дугаар сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Үзүүлэлт	Ашиглалтанд орсон он	Чанар багдал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Бүртгэх анхны		Эх үүсвэр	
								Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Сургалтын ширээ	SH-ZGD-65		2025	шинэ	ш	18	212,430.00	3,823,740.00	Дэлхийн зөн	Хандив
2	Сурагч сандал	SH-YGD-52		2025	шинэ	ш	18	134,830.00	2,426,940.00		
Нийт бүртгэх хөрөнгийн дүн									6,250,680.00		